

ГЕО-МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
2024 оны жилийн эцсийн тайлан

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл -ийн хувь
					Бүтэн жил		
Зорилго 3. Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах							
Зорилт 3.1 Хэрэглэгчийг мэдээллээр түргэн шуурхай найдвартай хангах зорилгоор Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн цахим санг баяжуулах. /ЗГҮАХ 3.2.4/							
3.1.1	Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн цахим санг /ҮГЭБМНЦС/ баяжуулах.	-	Баяжуулсан мэдээллийн тоо	Илрэл-3538 Худаг-2775 Цооног-5217 Шлихийн хүрээ-2705 Өрөмдсөн цооног-400 Эрдэсжсэн цэг-155 Хагарлын мэдээллийн сан-0	Нийт 1000 мэдээллээр баяжуулах	Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн цахим санг улсын төсвөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлуудын /Геологийн баримтын төв архивт хадгалагдаж байгаа/ үр дүнгийн тайлангаас Илрэл-5418, Уст цэг-8200, Цооног-5600 Шлихийн хүрээ-2966, Өрөмдсөн цооног-1300 Эрдэсжсэн цэг-201, Хагарлын м/с-2350 Нийт 11245 ширхэг мэдээллээр баяжуулсан.	100%
3.1.2	Геологийн онцлог тогтцын суурь мэдээллийн санг	2,0 тэрбум	Баяжуулсан мэдээллийн тоо	9176	Нийт 500 мэдээллээр баяжуулах	Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн цахим санг хөгжүүлэх зорилгоор УТХ-өөр гүйцэтгэж байгаа “Геологийн баримт-1” төслийн ажлын хүрээнд вэб сайтын хэсэгт 5833 нийтлэл, МонГеоКат системд метадата 4880 ширхэгийг оруулж нийт 10713 өгөгдлөөр баяжуулсан.	100%
3.1.3	Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг баяжуулна.	2,0 тэрбум	Баяжуулсан мэдээллийн тоо	608	Нийт 500 мэдээллээр баяжуулах	Цахим архивыг баяжуулах ажлаар Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Цахим архив-1, Чулуун дээжийн сан-1 төслүүдийн гүйцэтгэлийн хүрээнд eDOC архивын программд 277 тайлангийн 1122 хадгаламжийн нэгжийн 27432 хуудас, 6649 зураг оруулж мэдээллээр баяжуулсан. Нийт 13282 файлыг хөрвүүлэн мэдээллийг баяжуулсан. Системд Чулуун дээж-1039 Шлиф-2893 Аншлиф-330 өгөгдөл оруулж нийт 4262 мэдээллээр баяжуулсан.	100%

Зорилт 3.2. Хэрэглэгчийг мэдээллээр түргэн шуурхай найдвартай хангах зорилгоор геологийн төрөл бүрийн мэдээллээр төрөлжсөн, нэгдсэн цахим сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах /ЗГҮАХ 3.2.4/

3.2.1	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн төрөл бүрийн судалгааны ажлын үр дүнд зохиосон геологийн зургийг хүлээн авч цахим санг шинээр бүрдүүлэх, баяжуулах, тэдгээрийг боловсруулж хэрэглэгчийг мэдээллээр хангана.	-	Хүлээж авсан тайлангийн тоо	172	175	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж үр дүнгийн тайлангаа ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн хамгаалсан 1. УГЗ-200 D-VII, 2. Дөч гол-50, 3. Улаанбаатар геоэкологи 4. Асгат уул-50 зэрэг 4 тайлангийн тоон мэдээллийг шалган хүлээн авсан.	100%
3.2.2	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн төрөл бүрийн масштабын геофизикийн судалгааны үр дүнгээр цахим сан шинээр бүрдүүлэх, баяжуулах, тэдгээрийг боловсруулж хэрэглэгчийг мэдээллээр хангана.	-	Боловсруулсан тайлангийн тоо	126	136	Геологийн баримтын төв архивт хадгалагдаж байгаа 5680, 6635, 5781, 5624, 8455, 7940, 9950, 10155, 10065 дугаартай 9 тайлангийн үр дүнгийн зургуудаас эрлийн 17-н талбайн геофизикийн зургийг боловсруулан цахим санг баяжуулсан.	100%
3.2.3	Ашигт малтмалын орд, нөөцийн улсын тоо бүртгэл хөтөлж хэрэглэгчийг нууцад хамааруулснаас бусад мэдээллээр хангана.	-	Хөтлөлт хийсэн ордын тоо	3137	3213	ЭБМЗ-ийн гаргасан дүгнэлтийг үндэслэн ҮГА-ын даргын тушаалын дагуу 76 ордын нөөцийн давхцалыг хянан, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулсан. Ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд шинээр 65 нөөцийн мэдээллийг бүртгэв (Геологийн баримтын төв архивт тушаагдсан хайгуулын тайлангийн дугаар 10321, 10323, 10329, 10331, 10332, 10333, 10335, 10336, 10347, 10349, 10362, 10374, 10379, 10388, 10386, 10387, 10389, 10417, 10422, 10429, 10437, 10454, 10711, 10713, 10715, 10722, 10728, 10729, 10736, 10743, 10745, 10755, 10757, 10759, 6402, 9999, 10444, 10445, 10447, 10448, 10449, 10450, 10740, 10741, 10751, 10753, 10758, 10760, 10761, 10762, 10763, 10775, 8554, 9274, 9407, 9445, 10163, 10266).	100%
3.2.4	Шинээр тогтоогдсон илрэлийн мэдээллээр нэгдсэн цахим санг баяжуулна.	-	Баяжуулсан илрэлийн тоо	8931	8951	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар тогтоогдсон илрэлүүдийг Ашигт малтмалын илрэлийн санд бүртгэгдсэн илрэлүүдийн давхцалыг шалган шинээр 22 илрэлийг мэдээллийн санд бүртгэж, 9 илрэлийн мэдээлэлд нэмэлт баяжуулалт хийсэн.	100%

Зорилт 3.3 Төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгон хөгжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбох, төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгох /2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 5.3/

3.3.1	Мэдээллийн аюулгүй байдал, сүлжээ, удирдлагын төхөөрөмжүүдийн найдвартай ажиллагааг хангана.	-	0-хангагдаагүй 1-хангагдсан	1. Мэдээллийн системийн үндсэн төхөөрөмжүүдийн (физик сервер, дамжуулах болон хадгалах, нөөцлөх, хамгаалах) техник хангамжийн ашиглалт үйлчилгээг тогтмол хийж хэвийн ажиллагааг хангаж ажилласан 2. Серверийн өрөөний үл тасалдах цахилгаан тэжээл (UPS 3PH 10 KVA), хөргөлтийн (AirCondition 0N-9580AC) төхөөрөмжийн ажиллагаанд хяналт тавьж серверүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан. 3. Мэдээллийн системийн виртуал серверүүдийн үйлдлийн системийн хэвийн ажиллагаа хангаж windows үйлдлийн системийн сар бүрийн 12 удаагийн Cumulative Update for Windows Server шинэчлэлтүүдийг бүх серверүүдэд тогтмол хийсэн. 4. ҮГА-ны сүлжээний хамгаалалтын PaloAlto PA820 (sn: 012001051507, 012001051070) төхөөрөмжүүдийн PAN-OS үйлдлийн системийн шинэчлэлтийг зургаан удаагийн давталтаар 10.2.7 - 10.2.12-h1, Геологийн баримтын төв архивын сүлжээний хамгаалалтын PaloAlto PA440 (Sr - 021201083609) төхөөрөмжийн PAN-OS үйлдлийн системийн хувилбарыг зургаан удаагийн давталтаар 10.2.7 - 11.2.4 болгон шинэчилсэн. Хамгаалалтын болон удирдлагын тохируулгыг тухай бүрт хийж сүлжээний хэвийн ажиллагааг хангаж ажилласан. 5. Вирусийн эсрэг болон сүлжээний хамгаалалтын хяналтыг тогтмол хийж эрсдэлээс хамгаалах, удирдлагын Kaspersky Security Center программын хувилбарыг 14.0.0.10902 - с 15.1.0.20748, Ms Windows үйлдлийн системтэй 20 виртуал серверийн вирусын эсрэг хамгаалалтын Kaspersky Security 11 for Windows Server программын хувилбарыг 10.1.2.996 - с 11.0.1.897, Kaspersky Endpoint Security программын хувилбарыг KES-12.3.0.493-с 12.7.0.533, Network Agent хувилбарыг 12.2.0.4376-с 15.1.0.20748 болгож шинэчлэсэн ба хэрэглэгчийн компьютерийн хамгаалалтын хяналт үйлчилгээг тогтмол хийсэн 6. Байгууллагын хяналтын камерын хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Ажиллагаагүй болсон 3 дугаар давхарын хяналтын камерыг сольсон. 7. Мэдээллийн технологийн зүгээс ажилтан албан хаагчдын ажил үүргээ хэвийн явуулах нөхцөлөөр хангаж 38 компьютерт программ хангамжийн болон техник хангамжийн засвар, бусад төхөөрмжүүдийн тохируулгыг хийсэн. 8. АРВИС Системс ХХК-тай байгуулсан 24/21 тоот гэрээ байгуулж серверийн өрөөний Schneider Electric AirCondition SUAV 0332a загварын хөргөлтийн систем, хоёр ширхэг Schneider Electric Easy UPS 3S 10kVA загварын үл тасалдах тэжээл нөөцлөгчүүд, батарей, дагалдах автомат хэрэгслэлүүдэд техникийн бүрэн үзлэг, шалгалтыг хийлгэж шаардлагатай үйлчилгээг хийлгэсэн.			100%
3.3.2	Мэдээллийн сан, өгөгдлийн нэгдмэл байдлыг хангаж, төрийн үйлчилгээг нэгдсэн системд холбоно	-	0-холбогдоогүй 1-холбогдсон	1. Улсын геологийн зургийн редакцийн журам шинэчлэгдэн батлагдсантай холбоотой бүх зөвлөх ба гишүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг веб сайтад оруулж нийтэлсэн. Мөн улсын зургийн редакцияас зөвлөмж авах формыг хийж бөглөсөн мэдээлэл uzr@ngs.gov.mn хаяг руу илгээгдэхээр тохируулан веб сайтад нийтэлсэн. 2. Албаны веб сайтын (ngs.gov.mn) нэмэлт (plugin) уудыг (17) шинэчилж сайтын тогтвортой үйл ажиллагааг сайжруулж веб хуудас дуудах хурдыг сайжруулсан. Мөн Мэдээллийн сан бүрдүүлэх зааврыг нэмж байгууллагын бүтэц хэсгийн мэдээллийг шинэчилсэн. 3. 2024-оны 11-сарын 21-ний байдлаар албаны ngs.gov.mn сайт болон сошиал хуудсанд 2024-он гарснаас хойш нийт 40 төрлийн мэдээ мэдээллийг нийтэлсэн.			100%
Зорилт 3.4 Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэсэн геологийн болон сэдэвчилсэн судалгааны ажлын үр дүнгээр тогтоогдсон, сонгон шалгаруулалтаар олгох боломжтой, ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайн мэдээллийг нэгтгэж холбогдох төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах							
3.4.1	Судалгааны ажлуудын үр дүнгээр хуулиар хориглосон, хязгаарласан талбайтай давхцалгүй ашигт	-	Ялгасан талбайн тоо	508	200	Хуулиар хориглосон, хязгаарласан талбайтай давхцалгүй ашигт малтмалын хуримтлал бүхий 243 талбай ялгасан. Нийт 751 талбайг ялгасан.	100%

	малтмалын хуримтлал бүхий талбайг ялгана.						
Зорилт 3.5 Монгол Улсын ашигт малтмалын ордын нөөцийн тэнцэл /баланс/ гаргах, тайлагнах, хөтлөх							
3.5.2	Ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх, нөөцийн тэнцэл гаргана. /Төмөр, Зэс, Мөнгө, Цайр, Хар тугалга, Лити, ГХЭ /	-	Тэнцэл гаргасан ашигт малтмалын төрөл	0	11	Уран, Төмөр, Зэс, Мөнгө, Цайр, Хартугалга, Лити, ГХЭ гэсэн ашигт малтмалын төрлүүдээр нөөцийн хөдөлгөөнийг бүртгэж Улсын нөөцийн тэнцлийг гаргасан. ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлдэж байна.	80%
Зорилт 4.3 Улсын төсөвт орлого төвлөрүүлэх							
4.3.2	Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлийн мэдээ өгнө.	-	Орлогын хэмжээ /сая төгрөг/	0	11	Улсын төсөвт 39 900 000 төгрөгийн орлого оруулсан.	100%
Зорилт 5.1. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах							
5.1.1	Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын дагуу иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэнэ. /төр, хувийн хэвшлийн захиалгын дагуу үйлчилгээ үзүүлэх /	-	Шийдвэрлэлтийн хувь	100	100	УУХҮЯ-нд 15, Бусад төрийн байгууллагад 11, Иргэн, аж ахуйн нэгжид 44, Мэргэжилтэй мэргэжилтэнд 38 Нийт 108 ширхэг албан бичиг, хүсэлтэд хариу бэлтгэн хүргүүлсэн байна.	100%
Зорилт 5.2. Салбарын мэргэжилтэй боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах							
5.2.1	Албан хаагчдыг богино, дунд хугацааны сургалтад хамрагдана.	-	0-хамрагдаагүй 1-хамрагдсан	0	1		100%

5.1.1 Хүрсэн түвшин буюу хэрэгжилт

Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны захиалгаар

1. УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 11 сарын 22 өдрийн А/140 дугаартай ажлын хэсгийн хүрээнд 2024 онд шинээр хэрэгжүүлэх геофизикийн судалгааны ажлын талбайн геологийн даалгавар бичсэн.
2. УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 11 сарын 22 өдрийн А/140 дугаартай ажлын хэсгийн хүрээнд 2024 онд шинээр хэрэгжүүлэх геофизикийн судалгааны ажлын талбайн хэмжээг багасгаж, хассантай холбогдуулан талбайн зураг, ажлын хэмжээг дахин тооцоолж УУХҮЯ-ны ахлах шинжээч Х.Баярхангай болон Оргил нарт бэлтгэж явуулсан.
3. УУХҮЯамны Геологийн бодлогын хэлтсийн даргын үүрэг даалгавраар Монгол Улсын голлох ашигт малтмалын томоохон ордуудын мэдээллийг эдийн засгийн бүсчлэлээр нь бэлтгэж, дагалдах зургуудын хамт хүргүүлсэн.
4. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 481 дүгээр тогтоолоор 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Эдийн засгийн бүсчлэлээр нь хүн амын тоо (эрэгтэй, эмэгтэй), өрхийн тоогоор (өрх толгойлсон эх, өрх толгойлсон эцэг) нь мэдээллийг боловсруулж график байгуулсан.
5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/14 тоот тушаалын дагуу Ашигт малтмалын нөөцийн улсын балансын талаарх мэдээлэл бэлтгэх ажлын хүрээнд Аймаг тус бүрийн ашигт малтмалын төрлүүдээр ордын тоо болон нөөцийн нэгдсэн мэдээлэл гаргасан.
6. Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамны дэд сайд Б.Уянгад говийн бүсийн 4 аймгуудын 1:500000-ны масштабтай гидрогеологийн зураг, гидрогеологийн судалгааны байршлын зураг бэлдэж өгсөн.
7. УУХҮЯ-ны дэд сайд Б.Уянгын даалгаснаар Увс, Завхан, Ховд, Говь-Алтай аймгуудын нутагт тогтоогдсон голлох ашигт малтмалын ордуудын товч мэдээллийг жагсаалтаар бэлтгэж өгсөн.
8. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологийн бодлогын газрын дарга Х.Санчигдоржийн даалгавраар хүрэн нүүрсний ордуудын нөөцийн бүртгэлийн мэдээлэл болон ордын байршлын зургийг бэлтгэн цахимаар илгээсэн.
9. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргаас ирүүлсэн мэдээлэл авах тухай 2024 оны 03/657 тоот албан бичгийн хариуд “Монполимет” ХХК-ийн эзэмшиж буй Тосонгийн гольдрол нэртэй MV-000321 дугаартай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах Тосонгийн татамын алтны шороон ордын мэдээллийг шүүж нягтлан хариу хүргүүлсэн.

10. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас ирүүлсэн давхцал хянуулах тухай 2024 оны 03/277 дугаартай албан бичгийн дагуу "Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай" Засгийн газрын тогтоолын төслийн хавсралтад дурдсан талбайн солбицлуудын хүрээнд ашигт малтмалын орд, илрэлийн давхцлыг шалган албан тоотоор хүргүүлсэн.
11. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны *төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатараас ирүүлсэн* 2024 оны 03/727 дугаартай албан бичгийн дагуу Монгол оронд тогтоогдсон батерейн түүхий эд болох лити, бал чулуу, никель, кобальтын орд, илрэлийн мэдээллийг бэлтгэн албан тоотоор хүргүүлсэн. (jpeg болон excel файлыг damba@mmh.gov.mn цахим хаягаар илгээсэн).
12. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны *төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатараас ирүүлсэн* 2024 оны 03/613 дугаартай албан бичгийн дагуу Дорноговь аймгийн Мандах, Хөвсгөл болон Өргөн сумдын нутагт "Ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох тухай" Засгийн газрын тогтоолын төслийн хавсралтад дурдсан "Эрдэнэс Баянбогд" ХХК-д ашигт малтмал хайх эрх олгох Шар толгод, Өргөн шохойн чулуу нэртэй талбайн солбицлыг шалгаж, давхцал бүхий талбайнуудын жагсаалт болон давхцлын зургийг бэлтгэн албан тоотоор хүргүүлсэн.
13. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны *төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатараас ирүүлсэн* 2024 оны 03/614 дугаартай албан бичгийн дагуу "Байгалийн нөөц болон дурсгалт газрын хилийн заагийг тогтоох тухай" Засгийн газрын тогтоолын төслийн хавсралтад дурдсан 19 талбайн солбицлыг шалгаж, давхцал бүхий талбайнуудын жагсаалт болон давхцлын зургийг бэлтгэн албан тоотоор хүргүүлсэн.
14. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны сайдын 2024.02.07-ны өдрийн А/38 тоот тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг. Монгол орны хайлуур жоншны ордуудын нөөцийн нэгдсэн тэнцлийг тооцох. 2017 оноос хойш ашиглалт явуулж, хөдөлгөөн хийгдээгүй хайлуур жоншны ордыг ашиглах 111 ашиглалтын тусгай зөвшөөрлийн нөөцийн бүртгэлийг АМГТГ-аас ирүүлсэн нөөцийн хөдөлгөөнтэй тулгалт хийсэн.
15. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас ирүүлсэн 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 03/951 тоот албан бичгийн дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын 14.2 км хатуу хучилттай авто зам, Хэрлэн голын 265 у/м гэсэн нэгжтэй бетон гүүрний барилгын ажилд шаардагдах 21 талбайн давхцалыг шалгаж зураг болон мэдээллийг бэлтгэн албан тоотоор хүргүүлсэн.

Бусад төрийн байгууллагад:

16. ЗГХЭГ-ын референт Д.Болдын захиалгаар 21 аймгийн ашигт малтмалын тоо, ордуудын жагсаалт гаргасан.
17. Геологийн судалгаа шинжилгээний төв ТӨҮГ-ын хэрэгжүүлж буй Цахим архив-1-2022 төслийн Архивын цахим сан үүсгэх нормын хэмжээг хянасан.
18. Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтсээс ирүүлсэн мэдээлэл гаргуулах тухай 2024 оны 4/700 тоот албан бичгийн хариуд MV-021583 тусгай зөвшөөрөл бүхий Илжигтэйн хөндийн доод хэсгийн алтны шороон орд, MV-011892 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Хүрээтийн хөндийн алтны шороон ордын нөөцийн хөдөлгөөний мэдээллийг шүүж, лавлагааг албан бичгээр илгээсэн.
19. Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчны газраас ирүүлсэн мэдээлэл хүсэх тухай 2024 оны 02/385 тоот албан бичгийн хариуд Нийслэлийн нутаг дэвсгэрт тогтоогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын орд, илрэлүүдийн мэдээллийг шүүж, тархалтын тойм зураг болон товч мэдээллийн жагсаалтыг албан бичгээр илгээсэн.
20. *Ашигт малтмал, газрын тосны газрын даргаас ирүүлсэн мэдээлэл авах тухай* 2024 оны 1/1119 тоот албан бичгийн хавсралтад дурдсан 11 аж ахуйн нэгжид дүйцүүлэн олгогдох 23 талбай, 1/1739 тоот албан бичгийн хавсралтад дурдсан УУНК ХХК-д дүйцүүлэн олгогдох 1 талбай, 1/2719 тоот албан бичгийн хавсралтад дурдсан 7 аж ахуйн нэгжид дүйцүүлэн олгогдох 12 талбай, 1/3552 тоот албан бичгийн хавсралтад дурдсан 2 аж ахуйн нэгжид дүйцүүлэн олгогдох 4 талбайд хамаарах ашигт малтмалын мэдээллийг шүүж нягтлан, байршлын зургуудын хамт тус тус албан тоотоор хүргүүлсэн.
21. БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн 2024 оны 1/682 тоот албан хүсэлтийн дагуу 2020-2023 онуудад шинээр тогтоогдсон барилгын материалын орд, илрэлийн мэдээллийн товч жагсаалтыг бэлтгэн Барилгын хөгжлийн төвийн мэргэжилтэн Э.Баянмөнхөд (95144168) цахимаар илгээсэн.
22. Ховд аймгийн засаг даргын орлогч Х.Батболд-оос ирүүлсэн ашигт малтмалын орд, илрэлийн давхцал шалгуулах тухай 2024 оны 1/593 тоот албан бичгийн дагуу ХА-84000039 дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн талбайд хамаарах ашигт малтмалын орд, илрэлийн давхцалыг шүүж хариуг илгээсэн.
23. АМГТГ-аас ирүүлсэн мэдээлэл хүсэх тухай 2024 оны 11/2497 тоот албан бичгийн дагуу Монгол улсын цайрын металлогений бүс, орд, илрэлийн байршлын зураг, цайрын орд, илрэлийн мэдээлэл, ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд 2016 оноос хойш жил бүр бүртгэгдсэн цайрын нөөцийн мэдээллийг бэлтгэн албан тоотоор хүргүүлсэн.
24. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн лавлагаа хүсэх тухай 2024 оны 04-239/15219, 04-239/15221 тоот албан хүсэлтүүдийн дагуу "Мондулаан трейд" ХХК-ийн эзэмшиж буй Улаан шивэртийн ам нэртэй MV-004910, MV-017100 дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбайд гүйцэтгэсэн эрэл хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн жагсаалт болон тайлангуудыг хүлээн авсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, Ашигт малтмалын газрын даргын тушаалыг архивыг хуулбар үнэн тэмдгээр баталгаажуулан албан тоотоор илгээсэн.
25. Дорноговь аймгийн Засаг даргаас ирүүлсэн мэдээлэл авах тухай 2024 оны 3/1072 тоот албан хүсэлтийн дагуу Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт тогтоогдож, ашигт малтмалын орд илрэлийн санд бүртгэгдсэн үнэт болон хагас үнэт чулуу буюу өнгөт чулууны орд, илрэлийн жагсаалтыг албан тоотоор илгээсэн.
26. Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс ирсэн 2024 оны 06/11801 тоот мэдээлэл ирүүлэх тухай албан бичгийн дагуу "Монполимет" ХХК-ийн MV-000184, MV-000321, MV-000191, MV017065, "Мон цемент билдинг материалс" ХХК-ийн MV-013681, MV-018964, "Эхлэл ургац энерги" ХХК-ийн MV-021268 тоот тусгай зөвшөөрөл буюу нийт 3 аж ахуйн нэгжийн 7 тусгай зөвшөөрлийн хэмжээнд нөөц хүлээн авсан тушаал дүгнэлтүүд, ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлийн тушаал дүгнэлтүүдийн хуулбар болон

1996-2021 он хүртэлх нөөцийн баланс, нөөцийн хөдөлгөөний тайлангаас тусгай зөвшөөрөл тус бүрийн олборлолтын мэдээг шүүж хуулбарлан архивын хуулбар үнэн тэмдгээр баталгаажуулж албан тоотоор илгээсэн.

Иргэн Аж ахуйн нэгжид:

27. Нон феррос майнинг монголиа ХХК-ийн 2023 оны 23/24 тоот албан бичгээр ирүүлсэн сансрын зураг авах тухай хүсэлтийн дагуу К-49-29-А, L-48-50-В, L-48-62-А, L-47-100-А, В, L-46-119-Б, В, Г, L-46-131-Б, М-45-119-А хавтгайнуудад Sentinel-2 хиймэл дагуулын мэдээллийг ашиглан сансрын зургийн боловсруулалтыг хийж улсын төсөвт орлого төвлөрүүлсэн.
28. Жоншит газар ХХК-ийн захиалгаар Монгол орны жоншны ордуудын байршил болон дэд бүтцийн зургийг бэлтгэж байна.
29. Монголын Алт ХХК-ийн захиалгаар Монголын орны эсийн орд, илрэлийн товч мэдээллийг жагсаалтаар бэлтгэн өгсөн.
30. АМГТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандалаас дүгнэлт хүргүүлэх тухай 2024 оны 1/174 албан бичгээр ирүүлсэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 5 дүгнэлтийг үндэслэн, нөөцийг бүртгэх тухай даргын тушаалын төслийг боловсруулж, хянуулж, батлуулан 2024 оны 1/90 тоотоор хүргүүлсэн.
31. Монголросцветмет ТӨҮГ-аас ирүүлсэн нөөцийн үлдэгдэл гаргуулах тухай 2024 оны 1/187 тоот албан бичгийн хүрээнд Баргилтын цайрын давхцамал хүдрийн ордын цайрын нөөцийн давхцалыг шүүж, лавлагааг албан бичгээр илгээсэн.
32. Эм Си Жэй майнинг ХХК-иас ирүүлсэн лавлагаа хүсэх тухай 2024 оны 24/03 тоот албан бичгийн хүрээнд XV-011447 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайд бүртгэгдсэн алтны илрэлийн газарзүйн солбицлыг цахим шуудангаар илгээсэн.
33. "Сэс ресурс" ХХК-ийн захиалгаар Монгол орны жоншны ордуудын байршил болон дэд бүтцийн зургийг бэлтгэн хэвлэж, ордын товч мэдээллийг жагсаалтаар бэлтгэн өгсөн.
34. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн 2024 оны 1 дүгээр сарын 23 ны өдрийн 01/141 тоот албан бичгээр ирүүлсэн "байгууллагын нээлттэй өгөгдлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан ирүүлэх тухай" албан бичгийн хариуг төлөвлөж хүргүүлсэн. (Д.Болдбаатар)
35. "Эрдэнэс" УТП ХХК-аас ирсэн 2024/01/10 тоот албан бичгийн хүрээнд шинээр байгуулагдахаар төлөвлөж буй 6 үйлдвэрлэл, технологийн паркийн 200 км радиуст хамрагдах ордын мэдээлэл, зургийн хамт бэлтгэж хүргүүлсэн.
36. "Сондор гэрэлтүүлэг" ХХК-ийн захиалгаар Монгол орны ордуудын зургийг 1:850000-ны масштабтайгаар хэвлэж өгөхөөр бэлтгэж байна.
37. Монгол анар трейд ХХК-иас ирүүлсэн тодорхойлолт гаргуулах тухай 2024 оны 01/15, 01/16, 01/17 тоот албан бичгүүдийн хүрээнд MV-005211, MV-005784, MV-010329 тусгай зөвшөөрлүүдийн талбайн нөөцийн бүртгэлийг шүүж, лавлагааг албан бичгээр илгээсэн.
38. Талст дискови ХХК-иас ирүүлсэн лавлагаа хүсэх тухай 2024 оны 23/05 тоот албан бичгийн хүрээнд MV-015077 тусгай зөвшөөрөл бүхий Хөтөл улааны хайлуур жоншны ордын нөөцийн үлдэгдлийг шүүж, лавлагааг албан бичгээр илгээсэн.
39. Евро базальт ХХК-иас ирүүлсэн хүсэлт гаргах тухай 2024 оны 01-33 тоот албан бичгийн хүрээнд XV-63000051 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийн давхцалыг шүүж, хариуг албан бичгээр илгээсэн.
40. "Эрдэнэс" УТП ХХК-аас ирсэн 2024/01/10 тоот албан бичгийн хүрээнд шинээр байгуулагдахаар төлөвлөж буй 6 үйлдвэрлэл, технологийн паркийн 200 км радиуст хамрагдах ордын мэдээлэл, зургийн хамт бэлтгэж, хэвлэж өгсөн.
41. "Сондор гэрэлтүүлэг" ХХК-ны захиалгаар Монгол орны ордуудын зургийг 1:850000-ны масштабтаар бэлтгэж, хэвлэж өгсөн.
42. Эрдэнэс үйлдвэр технологийн паркийн захиалгын дагуу зураг мэдээлэл бэлтгэх ажлын хүрээнд металл бус ашигт малтмалын ордуудын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын нэрийг шүүсэн.
43. Геологийн судалгаа шинжилгээний төв ТӨҮГ-ын хэрэгжүүлж буй Геологийн баримт-1, Цахим архив-2022, ЧДС-1 чулуун сан төслийн 2024 оны төсвийн тодотголын материалтай танилцсан.
44. Тефисмайнинг ХХК-иас ирүүлсэн мэдээлэл хүсэх тухай 2024 оны 24/50 тоот албан бичгийн дагуу MV-018291 тоот тусгай зөвшөөрөл бүхий Хөшөөтийн нүүрсний ордын захын хэсгийн нөөцийн хөдөлгөөний мэдээллийг шүүж, лавлагааг албан бичгээр илгээсэн.
45. Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН-ээс ирүүлсэн лавлагаа хүсэх тухай 2024 оны 80/24 тоот албан бичгийн хариуд XV-020883 тоот тусгай зөвшөөрлийн талбайн судалгааны мэдээллийг шүүж, лавлагааг албан бичгээр илгээсэн.
46. Монголросцветмет ТӨҮГ-аас ирүүлсэн тодорхойлолт хүсэх тухай 2024 оны 1/408 тоот албан бичгийн дагуу MV-012884 тоот тусгай зөвшөөрөл бүхий Өргөний хайлуур жоншны бүлэг ордын 9-р хүдрийн бүс дэх нөөцийн бүртгэлийн мэдээллийг шүүж, хариуг албан бичгээр илгээсэн.
47. Ундармал хүдэр ХХК-иас ирүүлсэн нэрийн давхцал шалгуулах тухай 2024 оны 006 тоот албан бичгийн дагуу XV-022087 тоот тусгай зөвшөөрөл бүхий Далан-Ухаагийн төмрийн хүдрийн ордын нэрийн давхцалыг шүүж, хариуг албан бичгээр илгээсэн.
48. Мон Лаа ХХК -ний 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 01/123 тоот албан бичгийг хүлээн авч танилцаж, мэдээллийг шүүж хариу өгсөн.
49. Хунт Өгөөж ХХК -ний 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 53 дугаартай албан бичгийг хүлээн авч танилцаж, мэдээллийг шүүж хариу өгсөн.
50. ШУТИС, Геологи, Уул уурхайн сургуулиас ирүүлсэн 2024 оны 05 сарын 09-ний өдрийн №129 тоот албан бичгийн дагуу Туул, Хараа голын ай савын суурь судалгааны тайлангийн жагсаалт, 1:500000-ны гидрогеологийн зураг, уст цэгийн мэдээллийг shape файлаар бэлтгэсэн.
51. Монгол Экспресс Эм Эн ХХК-ийн 2024 оны 06 сарын 06-ны өдрийн 24/17 тоот албан бичигт нөөцийн лавлагааг гаргасан.
52. "Эрдэнэ Монгол" ХХК-ийн 2024 оны 07 сарын 03-ны өдрийн 216/24 тоот албан бичгийн дагуу нөөцийн лавлагааг гаргаж, албан бичгээр илгээсэн.
53. 3 ширхэг худгийн мэдээлэл pdf файлаар хувь хүнд өгсөн. (15000 төгрөг)
54. Гео Актив ХХК-ийн 2024 оны 10 сарын 24-ний 2024/27 дугаартай албан бичгийн дагуу мэдээллийг шүүж, тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр судалгаа хийгдсэн тайлангийн жагсаалтыг хавсралтаар хүргүүлсэн.

55. Мета-алт-500 төслийн талбайд тогтоогдсон алтны орд, илрэл, эрдэсжсэн цэгийн товч мэдээллийг жагсаалтаар бэлтгэж өгсөн
56. Ямбат-Уул-50 төслийн талбайд тогтоогдсон ашигт малтмалуудын орд, илрэлийн товч мэдээллийн жагсаалт, үнэмлэхүй нас, стратиграфийн зүсэлт, палеонтологийн олдворын мэдээллийг шүүж бэлтгэн өгсөн.
57. ААН, иргэний захиалгаар (утасны дугаар 88545858) илрэлийн сангаас Өмнөговь, Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт тогтоогдсон алтны илрэлүүдийг паспортыг (126 ш) шүүж, хэвлэж өгсөн
58. Монголросцветмет ТӨҮГ, Монгол анар трейд ХХК, Талст дисковери ХХК, Евро базальт ХХК, Тефисмайнинг ХХК, Монголиан ийстрн пауэрплант ХХК, Жоншт газар ХХК, Рич майнинг ХХК, Рэдулкан ХХК, Мөнх өгөөмөр ХХК, Монголын алт (МАК) ХХК, Ар Пи Ти ХХК, Минералплас ХХК, Түмэн анд ХХК, Сүрлэг хангайн хөгжил ХХК, Талын хишиг флорит ХХК, Уулс мандал ХХК, Хур эрдэнэ баялаг ХХК, ПолиметПотала ХХК, Орчлон орд ХХК, Хаан шороо ХХК, Уулс ноён ХХК, Роял хангай ХХК, Учралт номт констракшн ХХК, Азийн хөх тэнгэр групп ХХК, Эрдэнэс алт ресурс ХХК, Нарийн гол гоулд ХХК, Хан Алтай ресурс ХХК, Монголросцветмет ТӨҮГ, Хос хүдэр майнинг ХХК, Бэрхийн нурамт ХХК, Монгол ураниум ресурс ХХК, СПЕК ХХК, Алтаргана хайрхан ХХК, Минюушиши ХХК, Талст молор ХХК, Оны өвөлжөө ХХК, Эрдэнэсийн эрэг ХХК, Борцэцэг ХХК, Эн Ди Пи ХХК, Сонор трейд ХХК, Алтай таван мандал ХХК, Талын алтан булаг майнинг ХХК, Дамбат ХХК, Монгол экспресс Эм Эн ХХК зэрэг 45 ААН-ийн 53 тусгай зөвшөөрлийн талбайд ашигт малтмалын ордын нөөцийн бүртгэл, нөөцийн давхцал болон орд, илрэлийн давхцалыг шалгаж, лавлагааг албан бичгээр илгээсэн.
59. Ундармал хүдэр ХХК, Манлай дорно ХХК, Скайлла монголиа ХХК, Энержи ресурс ХХК, Тост нутаг ХХК, Түмэн баянбулаг ХХК, Нарийн гол гоулд ХХК, Бодьмөр-Интернэшнл ХХК, Монгол ураниум ресурс ХХК, Оны өвөлжөө ХХК зэрэг 10 ААН-ийн 10 тусгай зөвшөөрлийн талбайд тогтоогдсон ашигт малтмалын ордын нэрийн давхцалыг шалгаж лавлагааг албан бичгээр илгээсэн.
60. Демон инженеринг ХХК-иас ирүүлсэн мэдээлэл хүсэх тухай 2024 оны №43 тоот албан хүсэлтийн дагуу Өндөр технологийн түүхий эд-2 төслийн ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа Li, Ni, Be, W, Mo, Sn, бал чулууны 26 ордын нөөцийн мэдээллийг бэлтгэн уг төслийг хариуцсан хэлтэст хүлээлгэн өгсөн.
61. Эм Жи Жи И Си ХХК-ын 2024 оны 04 сарын 29-ны өдрийн 24/024 тоот албан бичигт нөөцийн лавлагаа гаргаж өгсөн.
62. Түмэн баянбулаг ХХК-ын 2024 оны 05 сарын 10-ны өдрийн №ТББ2405-10/2 тоот албан бичигт нөөцийн лавлагаа гаргаж өгсөн.
63. СПЕК ХХК-ын 2024 оны 05 сарын 27-ны өдрийн 25/54 тоот албан бичигт нөөцийн лавлагаа гаргасан.
64. ХӨХ ТАЛСТ МАЙНИНГ ХХК-ын 2024 оны 05 сарын 31-ний өдрийн 024/03 тоот албан бичигт нөөцийн лавлагааг гаргаж өгсөн.
65. Хос Хас" ХХК-ийн 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 68 тоот албан бичгийн хариуг гаргаж өгсөн.
66. Металл Олт ХХК-иас ирүүлсэн лавлагаа авах тухай 2024 оны 24/54 тоот албан хүсэлтийн дагуу Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт орших "Мэндэхийн чулуут гол" нэртэй MV-021185 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах "Хулгарын худаг"-ын хайлуур жоншны ордын нөөцийн бүртгэлийн лавлагааг албан тоотоор хүргүүлсэн.
67. Хэндфүл сийд ХХК-иас ирүүлсэн лавлагаа авах тухай 2024 оны 24/10 тоот албан хүсэлтийн дагуу Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт орших Дөшийн уул нэртэй XV-022209 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай, Говь-Алтай аймгийн Дэлгэр, Есөнбулаг сумдын нутагт орших Их улаан уул нэртэй XV-022312 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай, Ховд аймгийн Дарви сумын нутагт орших Дарцагт уул нэртэй XV-022316 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай, Төв аймгийн Өндөрширээт сумын нутагт орших Номгон уул нэртэй XV-022321 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайнуудад хамаарах нөөц бүртгэгдсэн эсэх лавлагааг албан тоотоор хүргүүлсэн.
68. ГСШТ-ТӨҮГ-т "Ханбогд-2023" төслийн хүрээнд гүйцэтгэж байгаа "Спектрометрийн нэгжийг өөрчлөх" шаардлага хүргүүлэх тухай албан бичгийг боловсруулж илгээсэн.
69. "Эрдэнэс баянбогд" ХХК-иас ирүүлсэн лавлагаа авах тухай 2024 оны 01/51 тоот албан хүсэлтийн дагуу "Богд уул" XV-022117 тоот тусгай зөвшөөрлийн талбайд ураны болон нүүрсний нөөцийн мэдээлэл, ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдээгүй лавлагааг албан бичгээр гаргаж өгсөн.
70. "Билгэх сайхан уул" ХХК-иас ирүүлсэн лавлагаа авах тухай 2024 оны 24/13 тоот албан хүсэлтийн дагуу шүүж үзэхэд Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших "Билгэх-3" нэртэй XV-019481 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд нөөцийн мэдээлэл, ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдээгүй лавлагааг албан бичгээр илгээсэн.
71. "Жинжий майнинг" ХХК-иас ирүүлсэн лавлагаа авах тухай 2024 оны 88/14 тоот албан хүсэлтийн дагуу шүүж үзэхэд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт дах Уулзвар нэртэй талбайд ашигт малтмалын MV-016901 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах "Уулзвар" нэртэй алтны шороон ордын ил уурхайн аргаар ашиглах дараах техник-эдийн засгийн үндэслэлүүд Геологийн баримтын төв архивд бүртгэлтэй лавлагааг албан бичгээр илгээсэн.

Үдийн длага болон дотоодын мэргэжилтэн нарын захиалгаар:

72. Үндэсний Геологийн Албаны албан хэрэг хөтлөлтийн ABLE системийн 2024 оны ашиглалтын гэрээний төслийг боловсруулж гэрээг хоёр талаар батлуулсан. (Д.Болдбаатар)
73. Үндэсний Геологийн Албаны албан интернэт үйлчилгээний 2024 оны ашиглалтын гэрээний төслийг боловсруулж нийлүүлэгчид батлуулахаар илгээсэн. (Д.Болдбаатар)
74. Засгийн газрын хуралдаанаар Улсын ашигт малтмалын нөөцийг танилцуулахтай холбоотой цайр, хар тугалга, төмөр, цагаан тугалга, металл бус ашигт малтмалын зарим төрлийн (хайлуур жонш, шохойн чулуу, бал чулуу, гөлтгөнө, фосфорит, судлын кварц, цеолит, гантиг, эрдэс хөвөнгийн түүхий эд) ордуудын бүртгэгдсэн нөөц болон үлдэгдэл нөөцийн мэдээг гаргасан.

75. Үндэсний Геологийн Албаны Си НЭТ ХХК-тай 2024 оны интернэт үйлчилгээний №24/02 тоот гэрээг батлуулж ашиглалтын хугацааг сунгасан. (Д.Болдбаатар)
76. Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас ирсэн “Байгалийн нөөц болон дурсгалт газрын хилийн заагийг тогтоох тухай” 2024 оны 1 сарын 23-ны өдрийн 03/176 тоот албан бичгийн хүрээнд: Байгалийн нөөц болон байгалийн дурсгалт газарт авахаар төлөвлөж буй талбай болон Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөж буй төслүүдийн талбайн давхцалын зураг болон товч мэдээллийг гаргаж Геологийн судалгааны хэлтсийн дарга Р.Болд-Эрдэнэ-д өгсөн.
77. БНСУ-ын КИГАМ болон ГСШТ хамтарч Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт байрлах Хаг эрдэсжсэн (Ni-Co-Pb-Zn-Cr) талбайд 2024 онд гүйцэтгэх хээрийн судалгааны ажлын гэрээний төслийг бэлтгэсэн.
78. Эрдэс баялгийн судалгаа, төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Н.Мөнхбилэгийн үүрэг даалгавраар Эдийн засгийн 7 бүсийн хэмжээнд холбогдох орд, 1:50 000-ны эзлэх хувь, хүчинтэй байгаа ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрлийн эзлэх хувийг зураг болон мэдээллийн хамт бэлтгэж өгсөн.
79. Засгийн газрын хуралдаанаар Улсын ашигт малтмалын нөөцийг танилцуулахтай холбоотой хар тугалга, металл бус ашигт малтмалын зарим төрлийн (хайлуур жонш, шохойн чулуу, бал чулуу, гөлтгөнө, судлын кварц, цеолит, гантиг, эрдэс хөвөнгийн түүхий эд) ордуудын бүртгэгдсэн нөөц болон үлдэгдэл нөөцийг шүүсэн.
80. Геологийн судалгаа шинжилгээний төв ТӨҮГ-ын хэрэгжүүлж буй Геологийн баримт-1, төслийн 2024 оны төсвийн тодотголын материалтай танилцсан.
81. ГСХ-ийн мэргэжилтэн Д.Одонтуяад Монгол орны хэмжээн дэх эрдэст ус болон газар доорх усны баримжаат нөөцийн судалгааны төлөвлөлтийн зураг хийж өгсөн.
82. Эрдэс баялгийн судалгаа, төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн даргын үүрэг даалгавраар Геопаркийн талбайн хэмжээний гидрогеологийн зургийг (худаг, булаг, цооног) shape файл болгон бэлтгэж өгсөн.
83. 1990 оноос хойших хугацаанд Монгол орны хэмжээнд гүйцэтгэсэн гидрогеологийн судалгааны ажлын тайлангийн жагсаалт, байршлын зургийг бэлтгэсэн.
84. ГСШТ-ийн Эрэл үнэлгээ-4 төслийн шуурхай хяналтаар ажилласан.
85. Монгол Улс-БНФУ-ийн Геологи, уул уурхайн судалгааны товчооны хэрэгжүүлэх “Литий-Монгол” төслийн хамтын ажиллагааны төслийн шинэчилсэн талбайн хүрээнд гидрогеологийн зургийг боловсруулж өгсөн.
86. Засгийн газрын хуралдаанаар Улсын ашигт малтмалын нөөцийг танилцуулахтай холбоотой, металл бус ашигт малтмалын зарим төрлийн (хайлуур жонш, шохойн чулуу, бал чулуу, гөлтгөнө, фосфорит, судлын кварц, цеолит, гантиг, эрдэс хөвөнгийн түүхий эд) ордуудын бүртгэгдсэн нөөц болон үлдэгдэл нөөцийн мэдээг гаргасан.
87. Стратегийн 1, 2-р хавсралт дахь ордуудын нөөцийг тулган, ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдсэн нөөцийн хэмжээг гаргасан.
88. Монгол оронд тогтоогдсон ордуудыг 74 төрлөөр ангилан, ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдсэн нөөцийн хэмжээг гаргасан.
89. 2020-2023 онуудад шинээр тогтоогдсон ордуудын ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдсэн нөөцийн хэмжээг гаргаж, жагсаалт бэлтгэсэн.
90. Дагалдах ашигт малтмалын нөөц бүртгэгдсэн ордуудын жагсаалтыг нэгтгэж Эрдэс баялгийн судалгаа, төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Н.Мөнхбилэгт өгсөн.
91. Монгол орны томоохон ордууд болон дэд бүтцийн байршлын зургийг хэвлэхэд зориулж 600 орчим ордын гарал үүслийг нь тэмдэглэж жагсаалтыг бэлтгэсэн.
92. 2020 оноос хойш бүртгэгдсэн элс, элс-хайрганы ордуудын жагсаалтыг бэлтгэсэн.
93. 1990-2000, 2001-2014, 2015-2023 онууд тус бүрээр ашигт малтмалын ордуудын нөөцийн бүртгэлийн мэдээг шүүж бэлтгэсэн. 1990-2023 онуудад илрэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн илрэлүүдээс ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй давхацсан илрэлүүдийг ялган, дараагийн шатны эрэл хайгуулын ажлаар нөөц тогтоогдож орд болсон илрэлийн жагсаалтыг бэлтгэсэн.
94. ЭБМЗ-ийн “ашигт малтмалын хайгуулын асуудал хэлэлцэх” салбар хуралдааны 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн ХХ-2024-03 дугаар хуралдааны дэгт орсон 8 ордын талбайн хэмжээнд нөөцийн бүртгэл болон орд, илрэлийн давхцалыг шүүж Эрдэс баялгийн судалгаа төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Н.Мөнхбилэгт өгсөн.
95. Ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдсэн үүсмэл ордуудын нөөцийн бүртгэлийн болон тайлангийн жагсаалтыг гаргаж Эрдэс баялгийн судалгаа төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Н.Мөнхбилэгт өгсөн.
96. Эрдэс баялгийн судалгаа, төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Н.Мөнхбилэг, мэргэжилтэн А.Амаржаргал нарт илтгэл бэлтгэхэд нь зориулж критикал ашигт малтмалуудын (ГХЭ, Li, Ni, Co, Cu, Mo, W, Sn, CaF, бал чулуу) орд, илрэлийн тархалтын зургийг бэлтгэж өгсөн.
97. Монгол улсад Геологийн Алба үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойг тохиолдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн алба, Монголын Геологийн холбоодын нэгдсэн зөвлөл хамтран зохион байгуулсан “Геологичдын ажил мэргэжлийн уралдаан”-ны зохион байгуулалтад оролцсон.
98. Уул уурхайн 7 хоног Mining Week 2024 арга хэмжээний зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан /2024.10.02-10.04/.
99. 2024 оны хээрийн материал хүлээн авах ажлын хэсэгт орж ажиллав.
100. ГСХ-ийн мэргэжилтэн Х.Ганхуягт УТХ-өөр 2025 онд гүйцэтгэх ГЗЕЭА-50 Боршоо-50, Эрдэнэцагаан-50, Номингийн говь-50, Бүлэгчилсэн 1:50000-ны Буйр нуур-50, Дарьганга-50, Хавирга-50, нарийвчилсан геологийн судалгааны 1:25000-ны Хархорин, Даланзадгад, Чойбалсан талбайнуудын зураг болон талбайн хэмжээг гаргаж өгсөн.
101. ГСХ-ийн мэргэжилтэн Х.Ганхуягт Хөвсгөл аймгийн нутаг хийгдсэн 1:50 000, 1:200 000-ны масштабтай геологийн судалгааны зургууд болон, 1:200 000-ны масштабын геологийн судалгааны тайлангийн жагсаалт гаргаж өгсөн.
102. ЭБСТЭХэлтэс дарга Н.Мөнхбилэг: ГСШТ-ТӨҮГ-руу “Ханбогд-2023”, “Соронзон-2023” агаарын геофизикийн цогцолбор судалгааны хүрээнд хийгдсэн агаарын соронзон судалгаа, хэт нам давтамжийн гүний цахилгаан соронзон судалгаа, агаарын радиометрийн судалгаа, агаарын хүндийн хүчний судалгааны хэмжилтийн түүхий өгөгдөл (raw data)

болон боловсруулсан өгөгдөл (processed data) -ийг хэмжилтийн чанарын үзүүлэлтийг хянах зорилгоор авах тухай албан бичиг явуулж, ирүүлсэн дата хүлээн авч серверт хуулсан.

103. Стратегийн ордын жагсаалтад шинээр оруулахаар санал болгох ордын жагсаалтыг гаргахад зориулж, тусгай зөвшөөрлийн талбайг буулгаж зургийг бэлтгэсэн (Алтан хөндий, Алтан нар, Хан Алтай, Ухаа худаг-1 нэртэй алтны ордууд).
104. ГСХ-ийн мэргэжилтэн Х.Ганхуягт Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд гүйцэтгэх төлөвлөж буй 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын Боршоо-50, Эрдэнэцагаан-50, Номингийн говь-50, бүлэгчилсэн зураглалын ажлын Дарьганга-50, Буйр нуур-50, Хавирга-50, нарийвчилсан геологийн судалгааны Хархорин-25, Чойбалсан-25, Даланзадгад-25 төслүүдийн кадастрын давхцалын 9 зураг хийж өгсөн.
105. ГСХ-ийн мэргэжилтэн Х.Ганхуягт Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд гүйцэтгэх төлөвлөж буй 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын Боршоо-50, Эрдэнэцагаан-50, Номингийн говь-50, бүлэгчилсэн зураглалын ажлын Дарьганга-50, Буйр нуур-50, Хавирга-50, нарийвчилсан геологийн судалгааны Хархорин-25, Чойбалсан-25, Даланзадгад-25 төслүүдийн кадастрын давхцалын зургийн хүснэгт хийж өгсөн.
106. Монгол Улс-БНФУ-ын Геологи, уул уурхайн судалгааны товчооны хэрэгжүүлэх "Литий Монгол" төслийн хамтын ажиллагааны хүрээнд литийн хүдэржилтийн судалгаа хийх талбайд судлагдсан 1:200 000, 1:50 000-ны зураглалын болон региональ судалгааны илрэл, эрдэсжсэн цэг, сарнилын хүрээ, гэх мэт мэдээллийг ArcGIS дээр нэгтгэсэн.
107. Олон улсын геологийн 37 дугаар конгрессын зохион байгуулах хороотой байгуулсан санамж бичгийн хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Манлай сумд болон Дундговь аймгийн Өлзийт сумдын нутаг дэвсгэрт Ханбогдын массив, Шар цав, Байшин цав, Цагаан суварга зэрэг газруудыг үзэх хээрийн аялал зохион байгуулахад оролцсон.
108. "Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ" төслийн А2.6 дугаар зорилтод арга хэмжээний хүрээнд Монгол орны хайлуур жоншны судалгаа (геологи, ашигт малтмалын шинж чанар, технологи болон зах зээлийн судалгаа) хийж байгаа энэхүү ажлын хүрээнд Хэнтий, Дорноговь аймгууд дахь хайлуур жоншны сонгосон уурхайнуудтай танилцаж, BGR судалгаанд ашиглах агуулга өндөртэй болон дундаж, сул агуулгатай ордуудаас дээж авч ажиллаа.

Гүйцэтгэл үнэлсэн:

Үндэсний геологийн албаны дарга
(албан тушаал)
(огноо)
Тэмдэг

Төсвийн шууд захирагч

..... / Б.Мөнхтөр/
(гарын үсэг)

2024-12-12

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

.....
(албан тушаал)
(огноо)
2024-12-12

Нэгжийн дарга

.....
(гарын үсэг)

2024-12-12

Тайлагнасан:

Гео-мэдээллийн төвийн дарга
(албан тушаал)
(огноо)

Нэгжийн дарга

..... /Ц.Минжинсор/
(гарын үсэг)

2024.11.22

ГЕО-МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН СИСТЕМИЙН АДМИНИСТРАТОР
Д. БОЛДБААТАРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт %
Зорилт 3.1 Хэрэглэгчийг мэдээллээр түргэн шуурхай найдвартай хангах зорилгоор Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн цахим санг баяжуулах. /ЗГҮАХ 3.2.4/ <u>Арга хэмжээ 3.1.1</u> Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн цахим санг /ҮГЭБМНЦС/ баяжуулна.							
1	<u>Арга хэмжээ 3.1.1.1</u> Мэдээллийн системд ашиглагдаж байгаа 31 сервер виртуал серверүүдийн хэвийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажиллах <u>Арга хэмжээ 3.1.1.2</u> Нөөцлөлт хийх техник болон программ хангамжийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажиллах, мэдээллийн	Мэдээллийн системийн хэвийн ажиллагааг ажиллагаа: 0-хангаагүй 1-хангасан	1. Мэдээллийн системд ашиглагдаж байгаа 31 сервер; -Удирдлагын 10 - Өгөгдлийн 4 - Өгөгдлийн сан 4 - Веб 11 - Бусад (Template) 2 2. Нөөцлөлт хийх техник болон программ хангамж; - Dell EMC DD6300 (Avamar 19.3.0) - Dell PE R740xd (Veeam Backup 10)	1.Мэдээллийн системд ашиглагдаж байгаа 31 виртуал серверүүдийн хэвийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажиллах 2. Өгөгдлийн нөөцлөлтийг тогтмол хийх Ажлын өдөр бүр (Avamar) 2 сар тутамд (VeeamBackup & Replication)	1.Мэдээллийн системд ашиглагдаж байгаа 31 сервер виртуал серверүүдийн хэвийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажилласан. 2.Үндэсний Геологийн Албаны виртуал серверүүдийг нөөцлөлтийн ажиллагаанд тогтмол ашиглаж байгаа AVAMAR программаар 2004 оны 1 дүгээр сарын 1 нээс эхлэн ажлын өдөр бүрт гэсэн давталтаар 261 удаагийн нөөц авсан. 3. Veeam Backup & Replication программаар 2 дахь хувилбар болгон 2,4,6,8,10,12 дугаар саруудад бүх виртуал серверүүдийг давхар нөөцөлсөн.	2024.01.01 - 2024.12.31	100%

	нөөцлөлтийг тогтмол хийх						
Зорилт 3.3 Төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгон хөгжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбох, төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгох /2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 5.3/							
<u>Арга хэмжээ 3.3.1</u> Мэдээллийн аюулгүй байдал, сүлжээ, удирдлагын төхөөрөмжүүдийн найдвартай ажиллагааг хангана.							
2	<u>Арга хэмжээ 3.3.1.1</u> Мэдээллийн системийн үндсэн, болон туслах төхөөрөмжүүдийн техник хангамжийн ашиглалт үйлчилгээг тогтмол хийж хэвийн ажиллагааг хангах <u>Арга хэмжээ 3.3.1.2</u> Мэдээллийн системийн виртуал серверүүдийн үйлдлийн системийн хэвийн ажиллагаа хангах, удирдлагыг тогтмол хийх <u>Арга хэмжээ 3.3.1.3</u> Мэдээллийн системийн гадаад болон дотоод сүлжээний удирдлага хамгаалалт, халдлагаас урдчилан сэргийлэх, вирусын эсрэг	1-хангасан 0-хангаагүй	1. Физик сервер 4ш 2. Виртуал сервер 30 ш 3. Өгөгдөл хадгалах (Storage SCv3020) 1ш 4. Өгөгдөл нөөцлөх төхөөрөмж DD6300) 1ш 5. Сүлжээний хамгаалалт удирдлагын төхөөрөмж FireWALL PaloAlto 820) 2ш FireWALL PaloAlto 440) 1ш 6. Нэгдсэн сүлжээний хуваарилагч (Switch) 8ш 7. Өгөгдөл дамжуулах (SAN Switch) 2 ш 8. Тэжээл нөөцлөгч (UPS 3PH 10 KVA) 2ш 9. Серверийн хөргөлт	1.Мэдээллийн системийн үндсэн төхөөрөмжүүдийн (физик сервер, дамжуулах болон хадгалах, нөөцлөх, хамгаалах) техник хангамжийн ашиглалт үйлчилгээг тогтмол хийж хэвийн ажиллагааг хангах 2.Серверийн өрөөний үл тасалдах цахилгаан тэжээл (UPS 3PH 10 KVA), хөргөлтийн (AirCondition 0N-9580AC) төхөөрөмжийн ажиллагаанд хяналт тавьж серверүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангах. 3.Мэдээллийн системийн виртуал серверүүдийн үйлдлийн системийн хэвийн	1. Мэдээллийн системийн үндсэн төхөөрөмжүүдийн (физик сервер, дамжуулах болон хадгалах, нөөцлөх, хамгаалах) техник хангамжийн ашиглалт үйлчилгээг тогтмол хийж хэвийн ажиллагааг хангаж ажилласан. 2. Серверийн өрөөний үл тасалдах цахилгаан тэжээл (UPS 3PH 10 KVA), хөргөлтийн (AirCondition 0N-9580AC) төхөөрөмжийн ажиллагаанд хяналт тавьж серверүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан. 3. Мэдээллийн системийн виртуал серверүүдийн үйлдлийн системийн хэвийн ажиллагаа хангаж windows үйлдлийн системийн cap бүрийн 12 удаагийн Cumulative Update for Windows Server шинэчлэлтүүдийг бүх серверүүдэд тогтмол хийсэн. 4. УГА-ны сүлжээний хамгаалалтын PaloAlto PA820 (sn: 012001051507, 012001051070) төхөөрөмжүүдийн PAN-OS үйлдлийн системийн шинэчлэлтийг зургаан удаагийн	2024.01.01 — 2024.12.31	100%

хамгаалалтын бүхий арга хэмжээг авах <u>Арга хэмжээ 3.3.1.4</u> Ажилтан албан хаагчдын ажил үүргээ хэвийн явуулах нөхцөлөөр хангаж ажиллах		(AirCondition 0N-9580AC) 10. Байгууллагын хяналтын камер 19ш , NVR 2ш 11. Вирусын эсрэг хамгаалалтын цогц программ хангамж KSC-14.0.0.10902 KES-12.3.0.493 NetAgent-12.2.0.4376 12. Дотоод сүлжээний орчинд ашиглагдаж байгаа 176 тоног төхөөрөмж (компьютер, принтер, сканер гм) төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангах	ажиллагаа хангах, удирдлагыг тогтмол хийх 4. Вирусийн эсрэг болон сүлжээний хадлагын хамгаалалтын хяналтыг тогтмол хийж удирдлагын программ хангамжийн шинэчлэлт, үйлчилгээг тогтмол хийх 5. Байгууллагын хяналтын камерын хэвийн ажиллагааг хангаж ажиллах. 6. Мэдээллийн технологийн зүгээс ажилтан албан хаагчдын ажил үүргээ хэвийн явуулах нөхцөлөөр хангаж ажиллах	давталтаар 10.2.7 - 10.2.12-h1, Геологийн баримтын төв архивын сүлжээний хамгаалалтын PaloAlto PA440 (Sr - 021201083609) төхөөрөмжийн PAN-OS үйлдлийн системийн хувилбарыг зургаан удаагийн давталтаар 10.2.7 - 11.2.4 болгон шинэчилсэн. Хамгаалалтын болон удирдлагын тохируулгыг тухай бүрт хийж сүлжээний хэвийн ажиллагааг хангаж ажилласан. 5. Вирусийн эсрэг болон сүлжээний хамгаалалтын хяналтыг тогтмол хийж эрсдэлээс хамгаалах, удирдлагын Kaspersky Security Center программын хувилбарыг 14.0.0.10902 - с 15.1.0.20748, Ms Windows үйлдлийн системтэй 20 виртуал серверийн вирусын эсрэг хамгаалалтын Kaspersky Security 11 for Windows Server программын хувилбарыг 10.1.2.996 -с 11.0.1.897, Kaspersky Endpoint Security программын хувилбарыг KES-12.3.0.493-с 12.7.0.533, Network Agent хувилбарыг 12.2.0.4376-с 15.1.0.20748 болгож шинэчлэсэн ба хэрэглэгчийн компьютерийн хамгаалалтын хяналт үйлчилгээг тогтмол хийсэн. 6. Байгууллагын хяналтын камерын хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Ажиллагаагүй болсон 3 дугаар давхарын хяналтын камерыг сольсон. 7 Мэдээллийн технологийн зүгээс ажилтан албан хаагчдын ажил	
---	--	--	--	--	--

					үүргээ хэвийн явуулах нөхцөлөөр хангаж 38 компьютерт программ хангамжийн болон техник хангамжийн засвар, бусад төхөөрмжүүдийн тохируулгыг хийсэн. 8. АРВИС Системс ХХК-тай байгуулсан 24/21 тоот гэрээ байгуулж серверийн өрөөний Schneider Electric AirCondition SUAV 0332a загварын хөргөлтийн систем, хоёр ширхэг Schneider Electric Easy UPS 3S 10kVA загварын үл тасалдах тэжээл нөөцлөгчүүд, батарей, дагалдах автомат хэрэгслэлүүдэд техникийн бүрэн үзлэг, шалгалтыг хийлгэж шаардлагатай үйлчилгээг хийлгэсэн.		
--	--	--	--	--	---	--	--

Зорилт 5.1. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

Арга хэмжээ 5.1.1

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас яаманд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариуг хүргүүлэх арга хэмжээ авах, холбогдох журмын дагуу хэрэгжилтийн байдлыг нэгтгэн холбогдох газарт хүргүүлэх

3	№5.1.1 <u>Арга хэмжээ 5.1.1.1</u> Тухайн жилд авах мэдээллийн технологийн үйлчилгээний гэрээ хэлцэл байгуулах. <u>Арга хэмжээ 5.1.1.2</u> Удирдлагыг мэдээллийн технологитой холбоотой шийдвэр гаргахад шаардлагатай шийдэл,	1- Шийдвэрлэсэн 0- Шийдвэрлээгүй	1. АБЛЕ системийн ашиглалт, үйлчилгээний гэрээ. 2. Интернэт урсгалын үйлчилгээний гэрээ. 3. PaloAlto NGFW төхөөрөмжийн лицензийн сунгалтын гэрээ. 4. Домэйн нэрийн болон Positive SSL Wildcard хамгаалалтын	1. Албан хэрэг хөтлөлтийн АБЛЕ системийн 2024 оны ашиглалтын № 24/01 тоот гэрээг 2024 оны 1 дүгээр сарын 17 ны өдөр ЭЙБЛСОФТ ХХК-тай байгуулсан. 2. УГА-ны 2024 оны интернэт үйлчилгээний № 24/02 тоот гэрээг 2024 оны 1 дүгээр сарын 11 ны өдөр СиНэт ХХК-тай байгуулсан. 3. Domain (mris.mn домэйн) нэрийн болон SSL сертификатын (mris.mn Positive SSL Wildcard) 2024 оны сунгалтыг № 24/11 тоот гэрээг	2024.01.01 — 2024.12.31	
---	--	---	--	---	--	--

мэдээллээр хангах, шийдвэрлүүлэх <u>Арга хэмжээ 5.1.1.3</u> Мэдээллийн технологитой холбогдолтой санал хүсэлтэд хариу хүргүүлэх.			сертификатын сунгалт. 5. Серверийн өрөөний тэжээл нөөцлөгч UPS 3PH 10 KVA, хөргөлтийн SUAV 0332a төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээний гэрээ	2024 оны 4 дүгээр сарын 17 ны өдөр АЙТООЛС ХК-тай байгуулсан. 4. PaloAlto 440 NGFW төхөөрөмжийн лицензийн ашиглалтын хугацаа 2026 онд дуусах тул сунгалтын гэрээ байгуулаагүй. 5. Санхүүгийн бүртгэлийн ЮНИКУС онлайн программ хангамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн гэрээний хугацааг он дамнуулахгүй байхаар “ОРДИНАТ” ХХК-тай тохиролцож 2025 оны 1 сард гэрээг байгуулахаар хойшлуулсан. 6. Коника “Bizhub 287” хувилах төхөөрөмжийн засвар, үйлчилгээний гэрээний хугацааг он дамнуулахгүй байхаар “Санко Маркетинг Монголиа” ХХК-тай тохиролцож 2025 оны 1 сард гэрээг байгуулахаар хойшлуулсан. 7. Геомэдээллийн нэгдсэн системийн засвар, үйлчилгээ, хөгжүүлэлтийн гэрээний хугацааг он дамнуулахгүй байхаар “Хан Хөлгөн” ХХК-тай тохиролцож гэрээг 2025 оны 1 сард байгуулахаар хойшлуулсан. 8. Вирусийн эсрэг хамгаалалтын программ хангамжийн сунгалтын лиценз худалдан авах № PS2024.22, 24/30 тоот гэрээг 2024 оны 2024 оны 9 дүгээр сарын 3 ны өдөр	
---	--	--	--	---	--

					“ПРОГРИД СИСТЕМС” ХХК - байгуулж худалдан авалтыг хийж лицензийг идэвхжүүлсэн. 9. 5. eDOC, Онлайн Лавлагааны Систем (Олс) программын засвар, үйлчилгээний гэрээг “НЬЮСОНИК” ХХК-тай байгуулсан		
--	--	--	--	--	---	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

№	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт %
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5		6	7
	Ажлын гүйцэтгэлийг сайжруулах, хоцорч буй ажлуудыг эрчимжүүлэх, цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор удирдлагаас (Албаны дарга, хэлтсийн дарга, бусад төрийн байгууллагаас) өгсөн үүрэг даалгавар, иргэн аж ахуй нэгжээс ирсэн хүсэлт, зохин байгуулсан хурал зөвлөгөөнд оролцох	Өгөгдсөн үүрэг даалгар биелэгдсэн биелэгдээгүй	АМГТГ -ын мэдээллийн системийн • Сүлжээний хамгаалалт, удирдлагын РА-820 төхөөрөмжүүдийн НА горим алдагдсан, үйлдлийн системийн шинэчлэлт хийгдээгүй, хамгаалалтын дүрэм алдаатай • Domain Control-ын ажиллагаа доголдсон • Мэдээллийн системийн нөөцлөлт хийгдээгүй	АМГТГ -ын мэдээллийн системийн ажиллагааг хэвийн болгох, инженерүүдэд зааварчлага өгөх, дадлагажуулах	1 Үндэсний геологийн албаны 2025 оны төсвийн төсөлд мэдээлэлийн технологид шаардагдах төсвийн саналыг бэлтгэж удирдлагад хүргүүлсэн. 2. АМГТГ-ын инженерүүдийн хүсэлтээр: • АМГТГ -ын мэдээллийн сүлжээний холболтын бүдүүвч зургыг гаргаж өгөх • Сүлжээний хамгаалалт, удирдлагын РА-820 төхөөрөмжүүдийн ажиллагаагүй болсон НА горимыг ашиглалтад оруулж, үйлдлийн системийн шинэчлэлтийг хийж хамгаалалт удирдлагын тохируулгыг засварлах • Domain Control-д гарсан алдааг засварлах, шинээр тохируулах • Мэдээллийн системийн нөөцлөлтийг хийх серверийг бэлтгэх, VeeamBackup & Replication 10.0 програмыг		2024.01.01 - 2024.12.31	100%

